**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ 15МВТ-ЫН "БӨХӨГ" НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хянасан:

Төв аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн С.Эрдэнэцогт /                    /

Хэрэгжилтийг гаргасан:

"Тэнүүн гэрэл констракшн" ХХК-ийн

Гүйцэтгэх захирал С.Одбаатар                    /                    /

"Тэнүүн гэрэл констракшн" ХХК-ийн Зөвлөх,

Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн

Б.Амарсанаа            /                    /

**2022 он**

**АГУУЛГА**


ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА....2

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ....2

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ....3

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....3

1.1 АГААР....3

1.2 ХӨРС ....3

1.3 УС....5

1.4 УРГАМАЛ, АМЬТАН....6

1.5 ОСОЛ, ЭРСДЭЛ, ГАМШГААС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....8

2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....18

3. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....19

4. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....19

5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....20

6. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....21

7. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....22

ДҮГНЭЛТ....25

ТАЙЛБАР....28

ХАВСРАЛТ....29

## ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Бөхөг" 15МВт нарны цахилгаан станц нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах ба тус сумаас 31 км, Зуунмод сумаас 29 км. Мөн Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос 68 км зайд, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудлаас баруун урд зүгт 14., 20225 км зайд оршино. Төслийн бүтээн байгуулалтын хүрээнд нийт 48га талбайд нэгж бүр нь 320 Вт -ын хүчин чадалтай 51372 ширхэг нарны дэлгэц ашиглан суурилуулалтын ажлууд хийгдсэн. Мөн удирдлагын байрны барилгын ажил, дэд станцын барилга угсралтын ажил хийгдсэн. НЦС нь уламжлалт цахилгаан станцыг бодвол хүлэмжийн хий ялгаруулдаггүй, хаягдал гаргадаггүй онцлогтой тул байгаль орчинд эерэг үр дагавартай. Цаашилбал, НЦС ашиглалтад орсноор Монгол Улсын гаднаас импортлох цахилгааны хэмжээ буурч, орон нутгийн дэд бүтэц, эдийн засагт эерэг нөлөөтэй. Тус нарны цахилгаан станц нь 25 жилийн турш жилдээ ойролцоогоор 29.632 ГВт.ц байгальд ээлтэй цэвэр эрчим хүч үйлдвэрлэх болно. Энэ нь жилд 30 мянган тонн хүлэмжийн хийн бууралтыг бий болгох ба 23.42 мянган тонн нүүрс, 146.5 мянган тонн усны хэрэглээг жилдээ хэмнэх үр ашигтай юм.

## ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

1. Ашиглалтын үед төслийн үйл ажиллагааны нөлөөлөл ихэнхдээ эерэг байх нь тодорхойлогдсон.
2. Энэ үед ашиглагдах үйлчилгээний цөөн тооны тээврийн хэрэгслийг эс тооцвол агаар бохирдуулах өөр эх үүсвэр байхгүй.
3. Нарны цахилгаан станц нь ажиллах явцдаа дуу шуугиан гаргадаг эх үүсвэрт тооцогддоггүй. Харин цаашид дэргэдэх онгоцны буудлын дуу шуугианы түвшнийг тооцож ажиллах хэрэгтэй.
4. Нарны цахилгаан үүсгүүрийн гялбааны эсрэг бүрхүүлтэй загвар сонгосон бөгөөд гэрлийг дотроо шингээдэг тул орчин тойронд гялбаа үүсгэхгүй гэрлийн ойлт, гялбааны нөлөөлөлгүй.
5. Унд ахуйн усыг гүний худгаас авж байгаа бөгөөд сумын ЗДТГ-тай ус ашиглах гэрээ хийн, зөвшөөрөл авч худаг гаргасан.
6. Ахуйн бохир усыг зориулалтын септик системд хуримтлуулж усыг 5тн багтаамжтай септик системд хуримтлуулан, ойролцоогоор 3 жилд 1 удаа аймаг орон нутгийн холбогдох байгууллага, ААН-тэй гэрээ байгуулах замаар үйлчилгээ авч, ариутгах татуургад нийлүүлнэ.
7. Бөхөг НЦС нь 2022 оны 10-р сарын байдлаар нийт 25.481 сая.кВт ЦЭХ үйлдвэрлэж төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлсэн бөгөөд дулааны цахилгаан станцтай харьцуулахад 25.79 мянган тонн хүлэмжийн хийн бууралтыг бий болгосон ба 20.14 мянган тонн нүүрс, 125.97 мянган тонн усны хэрэглээг хэмнэж, үр ашигтай ажиллаж байна.
8. Хорт бодис ялгаруулахгүй, дуу шуугиан үүсдэггүй зэрэг нь иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй эрчим хүчний үйлдвэрлэл юм. Ашиглалтын явцад НЦС-ын ажиллагсдад болон үйл ажиллагаатай танилцахаар ирсэн зочдод аюулгүй ажиллагааны дүрэм болон техник ашиглалтын дүрмээр тогтмол зааварчилгаа өгч ажиллаж байна.

# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь төслийг хэрэгжүүлэхэд болон ашиглалтын үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох, түүний дагуу жил бүр байгаль орчныг хамгаалах талаар компанийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодотгож байхад оршино. “Тэнүүн Гэрэл Констракшн” ХХК-ын “Бөхөг” нарны цахилгаан станцын нь Японы Засгийн Газраас хэрэгжүүлж буй уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй бага нүүрстөрөгч бүхий төслүүдийг дэмжих ажлын хүрээнд “Хамтарсан Кредит Олгох Механизм”-ын төсөлд шалгарсан бөгөөд цаашид байгаль орчинд ээлтэй технологиор цэвэр эрчим хүч үйлдвэрлэн, Төвийн эрчим хүчний системд цахилгаан эрчим хүчийг нийлүүлж байна.

## 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 1.1. АГААР

Нарны цахилгаан үүсгүүр цахилгаан үйлдвэрлэх үйл ажиллагаанаас хүлэмжийн хий болон бусад хорт бохирдуулагч агаарт ялгаруулдаггүй, үйлчилгээнд хэрэглэгдэх тээврийн хэрэгслийг эс тооцвол өөр агаар бохирдуулагч эх үүсвэр байхгүй тул агаарын бохирдол бууруулах тусгайлсан арга хэмжээ шаардлагагүй . Ажилчдын тээвэрт 9115 УНБ дугаартай Ланд-76 маркийн автомашин, аж ахуйд 2071УБЭ дугаартай портер маркийн автомашин ашиглаж байна. Өдөр тутам техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, улсын авто тээврийн өвөл, зуны үзлэг оношилгоонд тогтмол хамрагддаг.






"Тэнүүн гэрэл констракшн" ХХК-ийн тээврийн хэрэгслийг хүлээлцсэн акт
/2021 оны 3 дугаар сар/

| Улаанбаатар-Бөхөг НЦС-ын чиглэл | | | | | | | | | Хүлээлгэн өгсөн ХАБЭА-н инженерийн гарын үсэг | Бөхөг НЦС-Улаанбаатар чиглэл | | | | | | | | | Хүлээн авсан ХАБЭА-н инженерийн гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Огноо | Цаг, минут | Тээврийн хэрэгслийг хүлээн авсан этгээдийн нэр | Гарын үсэг | Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал: Толь | Цонх | Гэрэл дохио | Сав, зураас | Дугуй | | Огноо | Цаг, минут | Тээврийн хэрэгслийг хүлээн авсан этгээдийн нэр | Гарын үсэг | Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал: Толь | Цонх | Гэрэл дохио | Сав, зураас | Дугуй | |
| 23/III | 9^12 | [illegible] | [illegible] | √ | √ | √ | √ | √ | [illegible] | III/28 | 11^10 | Мөнхболд | [illegible] | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | [illegible] |
| 1/IV | 9^00 | [illegible] | [illegible] | √ | √ | √ | √ | √ | [illegible] | IV/01 | 12^20 | Б.Цэгц | [illegible] | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | [illegible] |
| 5/IV | 9^00 | [illegible] | [illegible] | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | [illegible] | IV/05 | 13^20 | Мөнхболд | [illegible] | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | [illegible] |
| 10/IV | 10^00 | [illegible] | [illegible] | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | [illegible] | [illegible] | 12^30 | Мөнхболд | [illegible] | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | [illegible] |
| 18/3 2021 | 10^50 | Мөнхбат | | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | [illegible] | 18/V 2021 | 13^00 | Мөнхбат | [illegible] | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | [illegible] |

*Зураг 1. Тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоо*

## 1.2. ХӨРС

Төслөөс гарч буй хатуу, шингэн бүх төрлийн хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж, зохих хаягдлын цэгт хаях, хөрс бохирдуулахгүй байх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг. Ашиглалтын явцад ахуйн хэрэглээнээс үүсэх 20л/хоног бохир усыг 5тн багтаамжтай септик системд хуримтлуулан, 3 жилд 1 удаа аймаг орон нутгийн холбогдох байгууллага, ААН-тэй гэрээ байгуулах замаар үйлчилгээ авч, ариутгах татуургад нийлүүлнэ. Ахуйн хатуу хог хаягдлыг байгууллага дээр тухайлсан цэгт ангилан, компанийн дотоод журмын дагуу өдөр бүр тээвэрлэн, хогийн цэгт хүргэдэг.

Тээврийн хэрэгслийг тогтоосон замаар явуулах зорилгоор 3 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээг зам дагуу суурилуулсан бөгөөд тэмдэглэгээний бүрэн бүтэн байдалд өдөр бүр тогтмол хяналт тавьж байна.



*Зураг 2. Замын тэмдэг тэмдэглэгээ*




Зураг 3. *Бохир ус хуримтлуулах хуванцар септик танк*

## 1.3. УС

Ашиглалтын үед ахуйн усыг ‘‘Усны тухай хууль’’-ын 27-р зүйл зааснаар зөвшөөрөлтэйгөөр худаг гарган, байгаль орчинд холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөн ажиллаж байна . 2018 оны 04-р сарын 06-нд Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ-тай гэрээ хийн, зөвшөөрөл авч, худаг гаргасан. (Ус ашиглах зөвшөөрлийн дугаар №А458). Ашиглалтын үед усны зарцуулалтыг хянан сар бүрээр усны хэрэглээг бүртгэн, баримтжуулж байна. 2021 оны 8-р сард цэвэр усны тоолуурыг баталгаажуулсан.
2022 оны 10 сарын байдлаар жилийн эхнээс 115.6т ус хэрэглэсэн байна.




Зураг 4. *Усны нөөцийн өрөө, усны тоолуурын заалт*

## 1.4. АМЬТАН, УРГАМАЛ

“Тэнүүн Гэрэл Констракшн”-ийн зөвлөх, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Б.Амарсанаа 2021.04.19-ний өдөр нийт ажилчдад төслийн талбай орчмоор агнуур хийхийг хориглох, хяналт тавих зааварчилгаа, 2021.10.25-ний өдөр нийт ажилчдад байгалийн ургамал түүх, ашиглахыг хориглох зааварчилгаа тус тус өгөв.




*Зураг 5. Төслийн талбай орчмоор агнуур хийхийг хориглох, хяналт тавих зааварчилгаа*




*Зураг 6. Байгалийн ургамал түүх, ашиглахыг хориглох зааварчилгаа*

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд тусгасан “Ховор болон нэн ховор зүйлийн шувуу талбайд илрэх магадлалтай тул хяналт мониторинг хийх” ажлын хүрээнд “Тэнүүн Гэрэл Констракшн”-ийн “Бөхөг” НЦС-ын талбайд 4 ширхэг шувууны үүрийг талбайн 4 буланд суурилуулж, 1 ширхэг шувуу суух суудал суурилуулан, ажиглалт хийж байна. Жил бүр шувууны үүр, суудлыг засаж, сайжруулах ажлыг гүйцэтгэдэг.



*Зураг 7. Шувууны үүр, шувуу суух суудал*




*Зураг 8. Шувууны үүрийг засаж буй байдал*

## 1.5. ОСОЛ, ЭРСДЭЛ, ГАМШГААС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашиглалтын үед ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, хөдөлмөр хамгааллын өдөр тутмын, тухайлсан, ээлжит болон ээлжит бус зааварчилгааг тогтмол өгч, ХАБЭА болон шаардлагатай ариутгал, халдваргүйжүүлэх материал хэрэгслээр ханган, осол авааргүй ажиллаж байна.







Зураг 9. *Ажиллагсад болон зочдод өгч буй өдөр тутмын болон тухайлсан зааварчилгаа*

Нийт ажилчдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг. 2022 оны 4-р сард нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан. Ажлын байрны ариутгал цэвэрлэгээг тогтмол хийж, хяналт тавьж ажиллаж байна.






*Зураг 10. Эрүүл мэндийн үзлэг, ариутгал хийж буй байдал*

*Хүснэгт 1. "Тэнүүн гэрэл констракшн" ХХК-ний "Бөхөг" НЦС-ын гал унтраах хэрэгсэл, аюулын гарц, цуглараx цэг, анхны тусламжийн хайрцаг*

*Зургийн нэр:Удирдлагын байр* — *Зураг №1*



*Зургийн нэр: Аврах гарцын зураг* — *Зураг №2*




*Зургийн нэр: 10кВ ХХБ ХХ-ын хэрэгсэл* — *Зураг №3*



*Зургийн нэр: ГАА-ны самбар* — *Зураг №4*




*Зургийн нэр: Цахилгааны ХХ-ын самбар* — *Зураг №5*




*Зургийн нэр:110кВ-ын ИХБ галын сараа* — *Зураг №6*




*Зургийн нэр: ЕН №1-8* — *Зураг №7*

*Зургийн нэр:ЕН №1-8 доторх галын хор 2ш* — *Зураг №8*

<table>
<tr>
<td colspan="2">
</td>
<td colspan="2"></td>
</tr>
<tr>
<td>Зургийн нэр: ЕН №1-8 галын дохиолол 1/4</td>
<td>Зураг №9</td>
<td>Зургийн нэр: ЕН №1-8 галын дохиолол 2/4</td>
<td>Зураг №10</td>
</tr>
<tr>
<td colspan="2"></td>
<td colspan="2"></td>
</tr>
<tr>
<td>Зургийн нэр: ЕН №1-8 галын дохиолол 3/4</td>
<td>Зураг №11</td>
<td>Зургийн нэр: ЕН №1-8 галын дохиолол 4/4</td>
<td>Зураг №12</td>
</tr>
<tr>
<td colspan="2"></td>
<td colspan="2"></td>
</tr>
<tr>
<td>Зургийн нэр: ЕН №1-8 ГАА-ын самбар</td>
<td>Зураг №13</td>
<td>Зургийн нэр: ЕН №1-8 цахилгааны АА-ны самбар</td>
<td>Зураг №14</td>
</tr>
<tr>
<td colspan="2">
</td>
<td colspan="2">
</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| *Зургийн нэр: ЕН №1-8 ХХХ-ын булан* | *Зураг №15* | *Зургийн нэр: ЕН №1-8 галын сараа* | *Зураг №16* |
|   | |  | |
| *Зургийн нэр: Удирдлагын байран дахь анхны тусламжийн хайрцаг* | *Зураг №17* | *Зургийн нэр:Галын цуглах цэг* | *Зураг №18* |
|   | |  | |

“Тэнүүн гэрэл констракшн” ХХК нь ХАБЭА-н инженертэй бөгөөд жил бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.



БАТЛАВ,
"ТЭНҮҮН ГЭРЭЛ КОНСТРАКШН" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ .................... С.ОДБААТАР

“ТЭНҮҮН ГЭРЭЛ КОНСТРАКШН” ХХК-ИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН: ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ, БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, АХМАД Л.НЯМДАВАА

БОЛОВСРУУЛСАН: ХАБЭА-Н ИНЖЕНЕР М.ГАНТУЛГА

2021 ОН



АЖЛЫН БАЙРНЫ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 01911967

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "ТЭНҮҮН ГЭРЭЛ КОНСТРАКШН" ХХК

Хаяг: СЭРГЭЛЭН СУМ 4 ДҮГЭЭР БАГ

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, / гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж /анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1.4/
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7/

Олгосон: 2021 он 05 сар 28 өдөр
Хүчинтэй хугацаа: 2023 он 05 сар 28 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:
ТӨВ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ дарга ХУРАНДАА цолтой Н.ТӨМӨРБААТАР

Дүгнэлт гаргасан:
ТӨВ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Гал түймрийн улсын хяналтын байцаагч: АХМАД цолтой Р.ОТГОНБААТАР

/тэмдэг дарна/

*Зураг 11. Бөхөг НЦС-ын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт*

15 МВт Бөхөг НЦС-ын ИТА нарын дунд 2022 онд явуулах ээлжит сургалтын төлөвлөгөөний дагуу 2022 оны 1-р сарын 3-13-ний хооронд "Тэнүүн Гэрэл Констракшн"-ын нийт ИТА нарын дунд е/и Г.Соронзонболд Монгол улсын эрчим хүчний системийн өнөөгийн байдал чиг хандлага, ХАБЭА/и Б.Цэгц ААД I, II, III бүлэг, ААД хавсралт, ХАБЭА хууль, анхны тусламж, галын аюулгүй байдал, харуул хамгаалалт, а/и Ө.Болорцом PV модуль бүтэц зохион байгуулалт ашиглалт, инвертерийн бүтэц зохион байгуулалт ашиглалт, э/и Б.Гантөмөр ЦТҮ, батарей хураагуурын төрөл ашиглах зарчим, НЦС-д ашиглагддаг гар багаж хэрэгслүүдийн ашиглалт, э/и А.Ганзориг хүчний трансформаторын үүрэг зориулалт бүтэц, хэмжүүрийн трансформаторын үүрэг зориулалт бүтэц, э/и Л.Дэмчигсүрэн РХА-ын тухай, э/и Э.Мөнхболд таслуур, салгуур, ДХТ-ын бүтэц зохион байгуулалт ашиглалт, э/м Б.Жавхлан 10кВ ХХБ-ын бүтэц зохион байгуулалт ашиглалт сэдвээр тус тус сургалтыг цахимаар амжилттай зохион байгуулав.

2022 оны 01-р сарын 13, 10-р сарын 10-ний өдөр аваар эсэргүүцэх дасгалыг тус тус амжилттай зохион байгуулсан. 2022 оны 03-р сарын 2-ний өдөр нийт инженер техникийн ажилчдаас аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрмийн хүрээнд мэдлэгийн шалгалт авав. 2022 оны 04-р сарын 13-ний өдөр Төв аймгийн ОБГ-аас Бөхөг НЦС дээр галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгааг амжилттай зохион байгуулав.



БАТЛАВ. ТЭНҮҮН ГЭРЭЛ КОНСТРАКШН ХХК -ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР: /Г.СОРОНЗОНБОЛД/

БӨХӨГ 15МВт НЦС -ын инженер техникийн ажилтнуудын 2021 онд явуулах ээлжит сургалтын төлөвлөгөө

2021.12.20

| № | Сургалтын сэдэв | Хугацаа | Цаг | Сургалт явуулах багш | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | PV модуль бүтэц зохион байгуулалт, ашиглалт | I/03 18-20 | 1 | А/и Ө Болорцом | |
| 2 | Инвертер бүтэц зохион байгуулалт, ашиглалт | I/03 18-20 | 1 | А/и Ө Болорцом | |
| 3 | ААД I бүлэг | I/4 18-20 | 1 | ХАБЭА инженер Б Цэгц | |
| 4 | ААД II бүлэг | I/4 | 1 | ХАБЭА инженер Б Цэгц | |
| 5 | ААД III бүлэг | I/4 | 1 | ХАБЭА инженер Б.Цэгц | |
| 6 | ААД хавсралт | I/5 | 1 | ХАБЭА инженер Б.Цэгц | |
| 7 | ХАБЭА хууль | I/5 | 1 | ХАБЭА инженер Б.Цэгц | |
| 8 | Цахилгаан техникийн үндэс | I/6 | 2 | Э/и Б.Гантөмөр | |
| 9 | Батерей хураагуур төрөл ашиглах зарчим | I/6 | 1 | Э/и Б Гантөмөр | |
| 10 | Хүчний трансформатор үүрэг зориулалт, бүтэц | I/7 | 1 | Э/и А Ганзориг | |
| 11 | Хэмжүүрийн трансформатор үүрэг зориулалт, бүтэц | I/7 | 1 | Э/и А.Ганзориг | |
| 12 | РХА -ын тухай (Шугам, Хүчний трансформатор, шин) | I/10 | 2 | ~~Э/и А.Ганзориг~~ Э/и Л Дэмчигсүрэн | |
| 13 | Таслуур, салгуур, ДХТ -н бүтэц зохион байгуулалт, ашиглалт | I/11 | 2 | Э/м Э.Мөнхболд | |
| 14 | 10кВ ХХБ,Инвертерийн 10кВ ХХБ байгууламжийн бүтэц зохион байгуулалт, ашиглалт | I/12 | 1 | Э/м Б.Жавхлан | |
| 15 | Монгол улсын эрчим хүчний системийн өнөөгийн байдал, чиг хандлага | I/13 | 2 | Ерөнхий инженер Г.Соронзонболд | |
| 16 | Аваари эсэргүүцэх дасгал явуулах | I/14 | 2 | | |
| 17 | Анхны тусламж | I/14 | 1 | ХАБЭА инженер Б.Цэгц | |
| 18 | Галын аюулгүй байдал | I/14 | 1 | ХАБЭА инженер Б Цэгц | |
| 19 | Харуул хамгаалалт | I/14 | 1 | ХАБЭА инженер Б.Цэгц | |
| 20 | Байгаль орчны сургалт | I/14 | 1 | Э/и Б Гантөмөр | |
| 21 | Станцад ашигладаг багаж хэрэгслүүдийн ашиглалт | I/14 | 1 | ИТА нар | |

Хянасан: ХАБЭА инженер: /Б.Цэгц/
Боловсруулсан: Ашиглалтын инженер: /Ө.Болорцом/






*Зураг 12. 2022 оны ээлжит сургалтын төлөвлөгөө, цахим сургалтууд*




*Зураг 13. Аваар эсэрхгүүцэх дасгал*




*Зураг 14. Техник ашиглалтын дүрэм, , аюулгүй ажиллагааны дүрмийн шалгалт*




*Зураг 15. Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа*

‘‘Тэнүүн Гэрэл Констракшн’’ ХХК-ны ‘‘Бөхөг’’ НЦС-ын гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд НЦС-ын хашаанд ургасан өвс ургамал нь хээрийн түймэрт өртөж улмаар нарны цахилгаан үүсгүүр, тоноглолд галын аюул учруулах магадлалыг ихэсгэж байгааг тусгасан бөгөөд хээрийн гал түймрийн аюулаас сэргийлэх шороон зурвас байгуулах болон шаардлагатай хэсгүүдэд өвсийг хадаж, тайралт хийх зөвлөмж өгсөн. Үүний дагуу 2021 онд 06-р сараас 10-р сарын хооронд талбайд өндөр ургасан өвс, зэрлэг ургамлыг түүж, хадах ажлыг гүйцэтгэн ойр орчмын малчин өрхүүдэд өгсөн.




*Зураг 16. Талбайд зэрлэг ургамал түүх, хадах арга хэмжээ*

## 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022 онд хэрэгжүүлэх ажлын графикт элсний нүүлтээс хамгаалах, ойн зурвас байгуулах ажлыг тусгасны дагуу 2022 оны 05-р сарын 15-нд нарны цахилгаан станцын хойд хашааны дагуу нийт 200 ширхэг хайлаас мод тарьсан. Жил бүр тарьсан моднуудын усалгаа, арчилгааг тогтмол хийдэг.




*Зураг 17. НЦС-ын талбайд хийгдсэн ногоон байгууламж*




*Зураг 18. Модны усалгаа*

## 3. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Тэнүүн Гэрэл Констракшн" ХХК -ийн 000320330, 000329710 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй Сэргэлэн сумын 4-р багийн нутагт байрлах газар нь орон нутгийн иргэдийн эзэмшил газартай давхцаагүй бөгөөд төслийн дэд бүтэц, барилга байгууламж, НЦС нь аливаа орон нутгийн иргэдийн эзэмшил газартай давхцаж, нүүлгэн шилжүүлэх нөхцөл үүсэхгүй юм.

## 4. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Тэнүүн Гэрэл Констракшн" ХХК -ийн "Бөхөг-15МВт НЦС" нь байгаль орчинд ээлтэй, хор хөнөөлгүй, ашиглалтын хугацаа өндөр, засвар үйлчилгээ бага шаарддаг дэвшилтэт технологиудыг ашигласан. Трансформаторын тосыг /Karamay db-45/ 12 жилд нэг удаа сольдог бөгөөд үзлэг, шинжилгээний дүнгээс хамааран тосыг тухайн засварын ажлын үед нэмж хийнэ.Засвар үйлчилгээний үед трансформаторын тосыг юүлэх хар тосон түрхлэгтэй 20м$^3$ эзлэхүүнтэй ган савыг трансформаторын сууринд холболт хийн суурилуулсан.  Трансформаторын тосны цахилгаан даац, хроматографийн шинжилгээг ЦДҮС, ДЦС-IV, Техноимпекс ХХК-ийн лабораториудад хийлгэн, тогтмол хяналт тавин ажиллаж байна.




*Зураг 19. Трансформаторын тосыг цуглуулах сав*







*Зураг 20. Трансформаторын өдөр тутмын үзлэг*

# 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

НЦС -ын технологи нь үйлдвэрлэлийн явцад хог хаягдал болон бохирдол гаргадаггүй бөгөөд зөвхөн ашиглалтын явцад удирдлагын байрнаас ахуйн хог, хаягдал гарна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022 онд хэрэгжүүлэх ажлын графикт тусгасны дагуу хог хаягдлыг түр цэгт ангилан, ялгаж, байршуулан өдөр бүр зориулалтын цэгт зөөж хүргэж байна. 2022 оны 05-р сарын 18,19-нд НЦС-ын талбайн гадна орчныг 500 метрийн тойрогт хог түүж, их цэвэрлэгээ хийв. НЦС-ын удирдлагын байрны ахуйн бохир лагыг 2021 оны 08-р сарын 30-нд соруулсан.

*Хүснэгт 2. Хог хаягдлын менежмент*

**Өдөр тутмын хог хаягдлын менежмент**


















**Гадна орчны цэвэрлэгээ**









## 6. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Тэнүүн Гэрэл Констракшн” ХХК нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчин хариуцсан мэргэжлийн ажилтантай бөгөөд нийт 14 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. 2019.03.21-нд Бөхөг НЦС дээр Улсын комисс ажилласан бөгөөд улсын комиссын үүрэг даалгаврыг биелүүлж, 2019.07.04-нд “Эрчим Хүчний Зохицуулах Хороо”-ноос эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөө аван, үйл ажиллагаагаа явуулж байна. Долоо хоног бүрийн даваа гаригийн өглөө удирдах албаны шуурхай хуралтай байдаг. Төслийн хэмжээнд 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах удирдлага зохион байгуулалттай ажиллаж байна.




*Зураг 5. Удирдлага, зохион байгуулалтын схем*

*Хүснэгт 3. Ашиглалтын үеийн удирдлага, зохион байгуулалт*

| **Удирдлага зохион байгуулалт, хурал, зааварчилгаа** | |
|---|---|
|  |  |






## 7. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2021 онд хэрэгжүүлэх ажлын график “Тэнүүн Гэрэл Констракшн” ХХК нь төслийн үйл ажиллагааны танилцуулга хийж, тайлан мэдээг орон нутгийн оршин суугчдад тайлагнах уулзалтыг жилд 1-2 удаа зохион байгуулна гэж тусгасны дагуу төслийн талбайтай ойр орших малчин өрхүүдтэй 3-р сарын 29, 8-р сарын 21-нд уулзалт хийж, НЦС-ын ү/а-г танилцуулж, галын аюулгүй байдлын зааварчилгаа өгсөн.









*Зураг 22.Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалт*

*Хүснэгт 4. НЦС дээр гадны байгууллагаас ирсэн зочид*

2022.01.06-нд ЭХЗХ-ны зочид НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.




2022.01.07-нд Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.










2022.01.19-нд Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлын зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.






2022.02.05-нд ДҮТ-ийн зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.







2022.03.09-нд ADB-ын зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.







2022.03.14-нд Хөшигт д/ст-ын зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.






2022.03.16,17-нд ББЭХС Ховд НЦС-ын зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.







2022.04.07-нд МГТИС-ын оюутнууд Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.






2022.04.11-нд ИЗИС-ын оюутнууд Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.



2022.05.05-нд Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбооны зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.










2022.05.06-нд Шинэ Монгол сургуулийн оюутнууд Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.







2022.05.10-нд Ikon.mn-ий зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав.






| 2022.08.25-нд АНУ-ын ЭСЯ-ны зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав. |
| --- |
|   |
| 2022.09.08-нд АХБ-ны зочид Бөхөг НЦС-ын үйл ажиллагаатай танилцав. |
|     |

## ДҮГНЭЛТ

| | | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Биелэлтийн шалгуур | Гүйцэтгэл | Хэрэгжүүлсэн ажил |
|---|---|---|---|---|---|---|
| **Сөрөг Нөлөөллийг Бууруулах Арга Хэмжээний Төлөвлөгөө** | Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | “Тэнүүн гэрэл констракшн” ХХК-ний нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах | 100% | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022 онд хэрэгжүүлэх ажлын графикт тусгасны дагуу нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт 2022 оны 4-р сард хамруулахаар төлөвлөсөн . |
| | | Машин механизмыг хугацаат техникийн үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх, тээврийн хэрэгслийн хорт утааг стандарт түвшинд байлгах | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | “Тэнүүн гэрэл констракшн” ХХК-ний үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийг техникийн улсын үзлэг, оношилгоонд хамруулах | 100% | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022 онд хэрэгжүүлэх ажлын графикт тусгасны дагуу ажилчдын ээлж зөөвөрлөдөг 9115 УНБ дугаартай Ланд-76 маркийн автомашин, аж ахуйн 2071УБЭ дугаартай портер маркийн автомашин нь 2022 оны 10-р сард улсын техникийн үзлэг, оношилгоонд хамрагдсан. |
| | Хөрсний чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Төслөөс гарч буй хатуу, шингэн бүх төрлийн хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж, зохих хаягдлын цэгт хаях, хөрс бохирдуулахгүй байх | НЦС-ын төслийн талбайд | Ашиглалтын явцад гарсан хатуу хог хаягдлыг ангилан хогийн цэгт, шингэн хаягдал, бохирыг цэвэрлэх байгууламжид хүргэж зайлуулах | 100% | Ашиглалтын явцад ахуйн хэрэглээнээс үүсэх 20л/хоног бохир усыг 5тн багтаамжтай септик системд хуримтлуулан, түвшинг хянадаг, НЦС-ын удирдлагын байрны ахуйн бохир лагыг 2021 оны 08-р сарын 30-нд соруулсан. Ахуйн хатуу хог хаягдлыг байгууллага дээр тухайлсан цэгт ангилан, компанийн дотоод журмаар тогтоосон хуваарийн дагуу өдөр бүр тээвэрлэн, хогийн цэгт хүргэж байна. |
| | Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Бохир усыг зориулалтын битүүмжтэй саванд хадгалах | НЦС-ын төслийн талбайд | Битүүмжлэл өндөр соруулах боломжтой хийцтэй бохирын сав суурилуулах | 100% | MNS EN 12566-1:2011 стандартын шаардлагыг хангасан 5м$^3$ багтаамжтай полиэтилен септик танкийг АТМОР ХХК-аар суурилуулсан. |
| | Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Ховор болон нэн ховор зүйлийн шувуу талбайд илрэх магадлалтай тул хяналт мониторинг хийх | НЦС-ын төслийн талбайд | Төслийн талбайд ажиглалт хийж амьдрахад таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх | 100% | “Тэнүүн Гэрэл Констракшн”-ийн “Бөхөг” НЦС-ын талбайд шувуу суух суудал суурилуулсан, 4 ширхэг шувууны үүрийг талбайн 4 буланд суурилуулж, ажиглалт хийж байна. Жил бүр шувууны үүрийг засаж, сэлбэдэг. |
| | | Төсөл хэрэгжих талбайд агнуур хийхийг хориглох, хяналт тавих, ажилчдад зааварчилгаа өгөх | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | Зааварчилгаа өгч, сургалт зохион байгуулах | 100% | 2021.04.19-ний өдөр “Тэнүүн Гэрэл Констракшн” ХХК-ний зөвлөх, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Б.Амарсанаа нийт ажилчдад Төслийн талбай орчмоор агнуур хийхийг хориглох, хяналт тавих зааварчилгаа өгч сургалт явуулав. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Тээврийн хэрэгслийг тогтоосон замаар явуулах, хяналт тавих, замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах | НЦС-ын төслийн талбай хүрэх зам дагуу | | 100% | Тээврийн хэрэгслийг тогтоосон замаар явуулах зорилгоор 3 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээг зам дагуу суурилуулсан бөгөөд түүний бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, ажиллаж байна. |
| | | Нийт ажилчдад байгалийн ургамал түүх, ашиглахыг хориглох зааварчилгаа өгөх | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | | 100% | 2021.10.25-ний өдөр "Тэнүүн Гэрэл Констракшн"-ний зөвлөх, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Б.Амарсанаа нийт ажилчдад байгалийн ургамал түүх, ашиглахыг хориглох зааварчилгааг өгч, сургалт явуулсан. |
| | Осол эрсдэл гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ | Гал унтраах хэрэгсэл, аюулын гарц, цугларах цэгийг зохих газарт байрлуулах, холбогдох сургалт зохион байгуулах | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | Төв аймгийн Онцгой байдлын газартай хамтарсан сургууль зохион байгуулах | 100% | 2022 оны 04-р сарын 13-ний өдөр Төв аймгийн ОБГ-аас Бөхөг НЦС дээр галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгааг амжилттай зохион байгуулав. 2022 оны 01-р сарын 13, 10-р сарын 10-ний өдөр нийт инженер техникийн ажилчдыг аваар эсэргүүцэх дасгалд хамруулж, аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрмийн хүрээнд мэдлэгийн шалгалт авав. |
| | | Эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулах | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | Эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах | 100% | "Тэнүүн гэрэл констракшн" ХХК нь ХАБЭА-н инженертэй бөгөөд 2019 онд эрсдэлийн менежментийн үнэлгээг ЭС ЭС АЙ ЭМ ЭН ХХК -аар хийлгэж, зөвлөмж авсан.2022 онд Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд Төв аймгийн ОБГ-аар хянан, батлуулсан. |
| | | Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, осол, эрсдэлээс сэргийлэх, анхны тусламж үзүүлэх сургалтад хамруулах | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2019 онд хэрэгжүүлэх ажлын график 04-р сард хийхээр төлөвлөсөн. | 100% | 2022 оны 1-р сарын 3-13-ний хооронд ХАБЭА/и Б.Цэгц нийт ажилчдад галын аюулгүй байдлын сургалт, анхны тусламжийн сургалт болон ээлжит бус сургалт зааварчилгааг онлайнаар амжилттай зохион байгуулсан. |
| **Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө** | | Элсний нүүлтээс хамгаалах ойн зурвас байгуулах | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | Ойн зурвас байгуулах | 100% | 2022 оны 05-р сарын 15-нд 200 ширхэг хайлаас мод тарьсан бөгөөд нийт тариалсан моднуудад усалгаа, арчилгаа тогтмол хийж байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт** | Асгаралт болсон үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад байршуулах | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | Асгаралт гарсан үед шуурхай арга хэмжээ авах | 100% | Бөхөг НЦС-д 11 ширхэг галын сараа суурилуулсан бөгөөд гал унтраах багаж хэрэгсэл, шингээгч материал элсийг байрлуулан, ашиглаж байна. |
| | Нийт ажилчдад асгаралтын үед авах арга хэмжээний талаар зааварчилгаа өгөх | НЦС-ын төслийн ашиглалтын хүрээнд | Асгаралт гарсан үед ажиллах арга барилыг ажилчдад олгох | 100% | 2022 оны 01-р сарын 13, 10-р сарын 10-ний өдөр Аваар эсэргүүцэх дасгалыг дотооддоо зохион байгуулж, өдөр тутам зааварчилгааг өгч, үзлэг шалгалтыг тогтмол, хийн, ажиллаж байна. |
| **Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт** | Ангилан ялгах | НЦС-ын төслийн талбайд | Ашиглалтын үед гарсан хатуу болон ахуйн хогийг ангилах | 100% | НЦС-ын талбайд ашиглалтын үед гарсан хатуу хог, хаягдлыг төрөлжүүлэн ялгаж цуглуулан төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн, хаяж байна. |
| | Хог хаягдлыг тээвэрлэх | НЦС-ын төслийн талбайд | Ашиглалтын үед гарсан бүх хогийг ангилан хогийн цэгт зайлуулах | 100% | Ахуйн хатуу хог хаягдлыг байгууллага дээр ангилан, компанийн дотоод журмаар тогтоосон хуваарийн дагуу өдөр бүр тээвэрлэн, хогийн цэгт хүргэж байна. |
| **Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө** | | НЦС-ын төслийн хүрээнд | "Тэнүүн Гэрэл Констракшн" ХХК нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчин хариуцсан мэргэжлийн ажилтантай бөгөөд нийт 14 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. | 100% | 2022 оны 3-р сарын 15-нд нийт ажилчид Дэйл Карнегийн "Бид багаараа л ажилладаг" сургалтад хамрагдсан. 2022 оны 4-р сарын 22-нд ээлжийн инженер Л.Дэмчигсүрэн ДҮТ-ийн РХА-ийн сургалтад суусан. 2022 оны 5-р сарын 6-нд ээлжийн монтёр Б.Жавхлан ДҮТ-ийн ША-ийн сургалтад суусан. |
| **Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт** | | НЦС-ын төслийн хүрээнд | Жилд 1-ээс доошгүй удаа. | 100% | 2022 оны 3-р сарын 29, 8-р сарын 21-нд компанийн төлөөлөл төслийн талбайтай ойр орших малчин өрхүүдтэй уулзалт хийн, үйл ажиллагаагаа танилцуулсан. |
| **Дүн (Арифметик дундаж)** | | | | **100%** | |

**ТАЙЛБАР**

“Тэнүүн гэрэл констракшн” ХХК нь бүтээн байгуулалтын үйл ажиллагаа болон ашиглалтаас гарах хог хаягдлыг удирдахдаа хог хаягдлыг тусгайлсан горимын дагуу байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй хэлбэрээр цуглуулж, богино хугацаанд зайлуулан, орчныг цэвэрлэх зарчим баримталсан. Бүтээн байгуулалтын үед төслийн үйл ажиллагаанаас ялгарах хатуу болон ахуйн хаягдлыг түр цэгт ангилан, ялгаж, байршуулан, тогтоосон хуваарийн дагуу Төв аймгийн “Хот тохижуулах газар”-тай хамтран зориулалтын цэгт зөөж хүргэсэн.

Ашиглалтын явцад үүссэн хог, хаягдлуудыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж төвлөрсөн цэгт тээвэрлэн, хог хаягдлын менежментийн асуудлыг сайжруулах зорилго тавин ажиллаж байна. 2019.03.21-нд Бөхөг НЦС дээр Улсын комисс ажилласан бөгөөд улсын комиссын үүрэг даалгаврыг биелүүлж, 2019.07.04-нд “Эрчим Хүчний Зохицуулах Хороо”-ноос эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөө аван, үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дотооддоо 2022 онд БОМТ-өөр хэрэгжүүлэх ажлын график боловсруулан түүний дагуу ажилласан. Бөхөг НЦС нь 2022 оны 10-р сарын байдлаар нийт 25.481 сая.кВт ЦЭХ үйлдвэрлэж төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлсэн бөгөөд дулааны цахилгаан станцтай харьцуулахад 25.79 мянган тонн хүлэмжийн хийн бууралтыг бий болгосон ба 20.14 мянган тонн нүүрс, 125.97 мянган тонн усны хэрэглээг хэмнэж, үр ашигтай ажиллаж байна.

Короновируст цар тахлын үед улс оронд хэрэгжүүлсэн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд шуурхай зохион байгуулалтад орж, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, улсын онцгой байдлын комисс болон Төв аймгийн онцгой байдлын комиссын үүрэг даалгаврыг чанд мөрдөн ажилласан.

## ХАВСРАЛТ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Газрын гэрчилгээ
3. Усны ашиглах гэрээ, дүгнэлт
4. Хог хаягдлын гэрээ
5. Хаягдал усны гэрээ, дүгнэлт,
6. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт(хатуу хог хаягдал, хаягдал усны төлбөр)
7. Газрын төлбөр төлсөн баримт
8. Усны төлбөр төлсөн баримт
9. 2022 онд БОМТ-өөр хийгдэх ажлын график